



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/14.

Улаанбаатар хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.9, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 19/16 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэх, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.58-д, Нийслэлийн Засаг даргын “Дэмжлэг үзүүлэх тухай” 2019 оны А/86 дугаар захирамж, газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор зохион байгуулах “Бүргэдийн баяр” арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /В.Батчимэг/-т үүрэг болгосугай.


2. Тус арга хэмжээнд шаардагдах энэ тушаалын хавсралтад заасан 11 134 000 /арван нэгэн сая нэг зуун гучин дөрвөн мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Balsmo* Д.БАТСҮХ



1150500096

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 02
сарын 19 өдрийн А/14 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт



**“БҮРГЭДИЙН БАЯР” АРГА ХЭМЖЭЭНД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

2019.02.19

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бүргэдийн баярт оролцох бүргэдчдийн Баян-Өлгий- Улаанбаатар, Улаанбаатар- Баян-Өлгийн чиглэлийн онгоцны зардал /хоёр талдаа/	20 хүн	556 700	11 134 000
	Нийт дүн			11 134 000

-ooOoo-